

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2022 оны 04 дүгээр сарын мэдээ

2022.04.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын ээлжит 2 дугаар хуралдааныг хуралдуулж сумын 2022 оны төсвийн тогтоолын нэр төрлийг нь өөрчилж батлав. Мөн ИТХ-ын төлөөлөгчдийн ёс зүйн дүрэм, хороодын ажиллах журмыг хэлэлцэн баталлаа.

ГХУССЗ -с 04 дүгээр сарын 01-ны өдрөөс “Архигүй Баяндэлгэр” аяныг албан байгууллага, аж ахуй нэгж, багуудын дунд 06 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл зохион байгуулан ажиллаж байна.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 29 албан бичиг ирсний 14 нь хариутай, 11 –нь хугацаандаа, 3–нь хугацаа болоогүй байна.

Сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/44 тоот захирамжаар “Өсвөр үеийн сумын аварга шалгаруулах” барилдааныг зохион байгуулсан.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан “Аюулгүй байдал, эрүүл мэндийн соёлыг хамтдаа төлөвшүүлэе” уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян-2022 арга хэмжээг 04 дүгээр сарын 01-нээс 30-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулж байгаа бөгөөд 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/47 тоот захирамжаар ХАБЭА зөвлөлийг шинэчлэн байгууллаа.

Үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах иргэдийн үндэсний бичгийн хэрэглээг сайжруулах чиглэлээр сургалт, уралдаан тэмцээнийг зохион байгуулж байна.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: 2022 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ.

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг, тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтыг хуваарийн дагуу бүрэн олгогдсон.

Аймгаас авах санхүүгийн дэмжлэг , төсвийн орлого 583,9 сая төгрөгийн орлого төвлөрсөн.

Байгууллагын өр авлага ,төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч ЗГУСХС бүрэн мэдээлсэн .

Статистикийн байгууллагад хүргүүлэх сар улирлын мэдээ тайланг хугацаанд нь гаргаж явуулсан.

Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

ААНБайгууллага болон төсөвт газрууд тайлангаа санхүүгийн free balance программд шивж оруулаад байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайлангаа аймгийн төрийн сангийн хэлтэс, Өмчийн газар, Төрийн аудитын газруудаар хянан баталгаажуулж алдаа зөрчилгүй дүгнэлт авсан.

Төсөвт газрын нягтлан бодогч, нярав нар аймгийн өмчийн газраас зохион байгуулсан “Эд хөрөнгийн улсын тооллого” сургалтанд хамрагдсан. Мөн А-3 ын

сургалт, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс зохион байгуулж байгаа ОНХС-ын үйл ажиллагааг сайжруулах зэрэг сургалтанд холбогдох мэргэжилтэн нар хамрагдсан

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян 2022” арга хэмжээний хүрээнд төсөвт байгууллага аж ахуй нэгжүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг сурталчилан, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр гарын авлага бэлтгэн түгээн ажиллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Нийгмийн хамгааллын бодлогын талаар:

Ерөнхий боловсролын сургууль: Мэргэжлийн хичээлийн олимпиадын 2-ын даваа Сүхбаатар аймагт зохион байгуулагдаж тус бүр 9 хичээлээр багш нар сурагчдаа бэлтгэн амжилттай оролцлоо.

Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан Математикийн хичээлийн 2-ын давааны төрөлжсөн олимпиадад Д.Алтанцэцэг багшийн бэлтгэсэн 11Б ангийн сурагч М.Оюунханд “Математик”-ийн хичээлээр ХҮРЭЛ медаль хүртлээ.

Монголын түүхийн төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд ЕБС-ын Түүхийн багш Ж.Бадамханд нэгдүгээр байр эзлэж улсын олимпиадад оролцох эрх, Нийгмийн хичээлийн төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд А.Баярмаа багшийн бэлтгэсэн 12Б ангийн сурагч Б.Бадамцэцэг алтан медаль хүртэж улсын олимпиадад оролцох эрх, Нийгмийн хичээлийн төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд ЕБС-н Нийгмийн багш А.Баярмаа нэгдүгээр байр эзлэж улсын олимпиадад оролцох эрх, Орос хэлний төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд Б.Батжаргал багшийн бэлтгэсэн 9в ангийн сурагч Б.Үржинбадам алтан медаль хүртэж улсын олимпиадад оролцох эрх, Орос хэлний төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд Б.Батжаргал багшийн бэлтгэсэн 12Б ангийн сурагч Ууганзаяа хүрэл медаль хүртлээ

04 дүгээр сарын 14-нөөс 04 сарын 21 хүртэл 7 хоногийн хугацаанд “Архигүй Баяндэлгэр” аян ЕБСургууль дээр амжилттай явагдаж дараагийн байгууллагад хүлээлгэн өглөө. Уг аяны хүрээнд боршур, зурагт мэдээлэл тараан албан байгууллагуудын дунд Теннисний тэмцээнийг зохион байгууллаа.

04 сарын 18-наас 04 сарын 22 өдрийг хүртэл Ерөнхий боловсролын сургууль дээр “САЙН БАГШИЙН-САЙН ТЕХНОЛОГИ” ур чадварын уралдааны I шат амжилттай зохион байгуулагдлаа.

Соёл: Тухайн сард соёл урлагийн үйл ажиллагааг 8 удаа зохион байгуулж 832 хүнийг хамруулж ажиллаа. Хурал зөвлөгөөн бусад арга хэмжээ 3 удаа зохион байгуулагдлаа.

Аймгийн засаг даргын 2022 оны 03 сарын 22-ны өдрийн А/139 дугаар, сумын засаг даргын 2022 оны 04 сарын 20-ны өдрийн А/55 дугаар захирамжийн дагуу “Сүхбаатар 80” урлагийн наадмыг зохион байгуулах комисс байгуулагдаж, урлагийн наадамын бэлтгэл ажилд ороод ажиллаж байна.

Мөн Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн үйл ажиллагаанууд хуваарийн дагуу явагдаж байна.

Соёлын төвийн номын сан нь ажлын 8 цагаар тогтмол ажиллаж уншигч үйлчлүүлэгчдэд гэрээр болон танхимаар ном олгож байнгын уншигч 45, ирэгсэд 198 иргэнд 157 ном гэрээр олгож 18 иргэнд утсаар болон амаар лавлагаа өгч 9 татгалзал бүртгэлээ.

Судар эгшиглэн -2022 уралдааны 2-р шатанд оролцогчдын уншсан номын тэмдэглэлийг “Судах эгшиглэн-2022” болон Баяндэлгэр Соёлын төв группэд постолж уншигчдаа сурталчиллаа.

Төслийн 2-р шатанд уншигдах номын судалгааг хийж хэрэгцээт ном хэвлэлийг худалдан авах фондын баяжилтыг нэмэгдүүлэхээр ИТХ-д төсөл оруулж ном худалдан авах 1500.000 төгрөгийг батлууллаа.

Дэлхийн хүүхдийн номын өдөр болон дэлхийн номын өдрийг тохиолдуулан хүүхдийн номын үзэсгэлэн, шинэ номын үзэсгэлэн гаргаж сурталчиллаа.

Судар эгшиглэн төслийн оролцогч хүүхдүүдийн дунд ном уншихын ач холбогдол, уншсан номын тэмдэглэл хэрхэн хөтлөх талаар арга зүйн зөвлөмж өгч хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Баяндэлгэр Соёлын төв цахим группт уран зохиол-2022, соёлын өв-2022, судар эгшиглэн-2022, дотоод үйл ажиллагаа-2022 булангуудыг хөтлөн нийт 39 мэдээлэл орууллаа.

МУСТА Д.Бурмаагийн “Уянгалаг”, МУСТА Б.Гүрбадамын “Дурлал шиг бүсгүй”, “Чингис хаан” хамтлагийн “XXI зуун”, Жаахан шарга ХЖТ-ын “Хайрын бэлэг” тоглолтыг хүлээн авч ард иргэдэд хүргэлээ.

Цэцэрлэг: “Сайн багшийн сайн технологи” ур чадварын уралдааны 1-ийн давааг зохион байгуулж шалгарсан 1 багшийг бүсийн ур чадварын уралдаанд оролцуулан бүсдээ 2-р байр эзэлсэн амжилт гаргалаа.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй- 2022” сарын аяны хүрээнд өдөрлөг зохион байгуулж нийт 84 эцэг эх хамрагдлаа. Уг өдөрлөгөөр ажлын байрны дасгал, сургалтын хэрэглэгдэхүүний үзэсгэлэн, багш ажилчдын ажлын байрны хувцас, Хоол үйлдвэрлэл хоолны илчлэг шим тэжээлийн талаар мэдээлэл амталгаа, байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа гэсэн чиглэлээр явууллаа.

Орон нутгийн сургалт 2 удаа нийт 4, ажлын байрны сургалт 2 удаа давхардсан тоогоор 43 албан хаагч хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн байна. Туршлага солилцоонд 3 багш 1 ажилтан хамрагдлаа.

БШУЯ-ны баг бүрэлдэхүүн нэг өдөр байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа.

Архигүй Баяндэлгэр аянд нэгдэж “Спиртлэг биш спортлог байцгаая” хөгжөөнт буухиа тэмцээн аж ахуй нэгж, 6 багийн ард иргэдийн дунд зохион байгуулж архины хамааралтай буюу эрсдэлтэй 4 айлаар сумын цагдаагийн тасагтай хамтран зочилж зөвлөгөө зөвлөмж, сургалт сурталчилгаа зохион байгуулж 113 иргэн хамрагдсан. Сумын аж ахуй нэгж байгууллагад гарын авлага 80 ширхэгийг түгээн ажилласан.

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэгт-412 урьдчилан сэргийлэх үзлэг – 128 идэвхитэй хяналт- 84, дуудлагаар- 44, Больникод хэвтэн эмчлүүлсэн нийт - 36 иргэн байна. Элэгний В вирусээс урьдчилан сэргийлэх вакцины 1-р тунд 150 иргэн, 2-р тунд одоогоор 64 хүнийг хамруулаад байна.

Сумын ГХУССЗ -с зохион байгуулж байгаа “Архигүй Баяндэлгэр” аяны хүрээнд ахлах бүлгийн хүүхдүүдэд архины эрүүл мэндэд нөлөөлөх хор уршигийн талаар сургалт зохион байгуулж гар зургийн уралдаан зарлав. Мөн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байгаа иргэдэд зөвлөмж бэлтгэн түгээн ажиллаж байгаа бөгөөд Бөмбүүлэй цэцэрлэгийн 21 ажилтанд сургалт зохион байгуулсан

2022 оны 05 дугаар сарын 01-нээс орон даяар “Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэлт оношилгоог” зохион байгуулахтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх үзлэгийн бэлтгэл ажил хийгдэж эмч нар танхимын болон цахим сургалтуудад хамрагдаж байна.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт байгаль орчны чиглэлээр хийгдэх нийтийг хамарсан ажлын 3 төслийг хүргүүлэв.

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ийг суманд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1 модны нүх ухах ажлыг 3000 төгрөг байхаар тогтож ажиллах хүмүүсийг бүртгэж байна.

“Хашаандаа сайхан амьдаръя” 2 000 000 төгрөгийн шагналт болзолт уралдаан зохион байгуулах аяныг сумын хэмжээнд хэрэгжүүлэхээр удирдамж гарган ажиллаж байна.

Хөдөө аж ахуй: Сумын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 1 дэх өдөр аймгийн ХХААГазарт хүргүүлж байна. 04 дүгээр сарын 25 ны байдлаар сумын жишсэн дундаж хүн амын хоногийн хэрэгцээнд харьцуулснаар гурил – 66 хоног, гурилан бүтээгдэхүүн – 5 хоног, төрөл бүрийн будаа – 71 хоног, хуурай сүү – 26 хоног, өндөг – 4 хоног, ургамлын тос – 12 хоног, төмс – 15 хоног, хүнсний ногоо – 2 хоног, элсэн чихэр -24 хоног, давс – 60 хоног, ус – 4 хоногийн нөөцтэй байна. Мөн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг гаргаж ХХААГазарт хүргүүлсэн.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийг сар бүр дансны хуулагтай тулгаж, монгол банканд зээлийн мэдээллийг дамжуулсан. Тухайн сард зээл, зээлийн хүүгийн орлого 9,774,000 төгрөг төвлөрсөнөөс хугацаа хэтэрсэн 1 зээлдэгч 950,420 төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хийж, зээлийн өрийг бүрэн барагдуулсан.

Мал төллөлт, бойжилт, том малын хорогдлын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр ХХААГазарт, сар бүрийн эцэст статистикийн хэлтэст программд шивж орууллаа. Том малын хорогдол бүгд 213, тэмээ – 1, адуу- 2, үхэр- 12, хонь- 98, ямаа- 100 нийт малын 0,04% нь хорогдсон байна. Мал төллөлт бүгд 137788, ингэ- 76, гүү- 1221, үнээ- 1444, эм хонь- 80270, эм ямаа- 54777 буюу нийт малын 59,9% төллөсөн байна.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн